



Захиргааны хэм хэмжээний
аистын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 05 сарын 21-ны
өдрийн 7259 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 8473

Улаанбаатар хот


Г Эрүүл мэндийн байгууллагын
аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх,
дахин боловсруулах, устгах заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах зааврыг нэгдүгээр, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх зааврыг хоёрдугаар, Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Л.Баттөр)-т, мэргэжил арга зүйгээр ханганд ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан)-д тус тус даалгасугай.
3. Уг тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
4. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвтөө тусгахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/230 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Т.МӨНХСАЙХАН



141251016

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 сарын 01.-ны өдрийн 9:45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ ЗААВАР


Нэг. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын ангилал

Эрүүл мэндийн байгууллагаас үүсэж буй нийт хог хаягдлыг энгийн болон аюултай гэж 2 ангилна.

"Аюултай хог хаягдал" гэж Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасныг, "Энгийн хог хаягдал" гэж мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасныг ойлгоно.

Эрүүл мэндийн байгууллагаас үүсэж байгаа аюултай хог хаягдлыг халдвартай, хурц үзүүр иртэй, эмгэг, эмийн болон эсэд хортой нөлөөтэй, химийн бодисын болон цацраг идэвхт хог хаягдал гэж 6 ангилна.

Бүдүүвч 1: Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ангилал



1.1. Энгийн хог хаягдал

Энгийн хог хаягдалд эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гол тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуур, эм, урвалжийн гадна талын сав баглаа боодол, нэг удаагийн зүүний хуванцар таглаа (бохирлогдоогүй), хоол хүнсний үлдэгдэл зэрэг аюултай хог хаягдалд хамаарахгүй хаягдлууд орно.




Эрүүл мэндийн байгууллагын энгийн хог хаягдаас шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр, хуванцар, антибиотик, физиологийн уусмал зэрэг хоргуй эмийн флакон болон тарилгын шингэний хуванцар сав, уут зэрэг хог хаягдлыг тусад нь цуглуулж дахивар нөөцөд хамруулан дахин боловсруулж ашиглана. (Хүснэгт 1 А, Б).

Хүснэгт 1А. Энгийн хог хаягдал

Өнгө	ХАР
Таних тэмдэг	Тэмдэглэгээ, таних тэмдэг шаардлагагүй.
Цуглуулах	Хар өнгийн нийлэг уутанд хийнэ.
Хаяглалт	Шаардлагагүй
Устгал:	Тухайн орон нутгийн хог хаягдал хариуцсан тохижилт үйлчилгээний байгууллагад хүлээлгэн өгнө.

Хүснэгт 1Б. Дахивар нөөц

Өнгө	ӨНГӨГҮЙ
Таних тэмдэг	Цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын олон улсын таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.
Цуглуулах	Өнгөгүй нийлэг уут болон таних тэмдэг бүхий бусад төрлийн саванд хийнэ.
Хаяглалт	Лааз-шил, хуванцар, цаас гэх мэт
Устгал:	Хог хаягдал дахин боловсруулах байгууллагад хүлээлгэн өгнө.



1.2. Аюултай хог хаягдал

1.2.1. Халдвартай хог хаягдал

Халдвартай хог хаягдалд өвчин үүсгэгч бактери, вирус, шимэгч, мөөгөнцөр зэрэг эмгэгтөрөгч агуулсан хог хаягдлууд хамаарна. Тухайлбал:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад биологийн шингэнээр (биений өтгөн, шингэн ялгадас, цэр, шүлс, цус) бохирлогдсон эд зүйлс;
- Цус, цусан бүтээгдэхүүн;
- Тусгаарлах хэсгийн халдвартай өвчтөн, олон эмэнд тэсвэртэй бичил биетний халдвартай үйлчлүүлэгчээс гарах хог хаягдал (ариун цэврийн болон хоол хүнсний үлдэгдэл гэх мэт);
- Вакцин, био бэлдмэл;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэсэн хамгаалах хувцас, нэг удаагийн хэрэгсэл;
- Лабораторид үүсэх хүн, амьтанд халдвэр дамжуулах эрсдэл бүхий эмгэг төрөгчөөр бохирлогдсон өсгөвөр, тэжээлт орчин болон тэдгээртэй харьцаж ажиллахад ашиглагдаж буй багаж, хувцас хэрэгсэл;

- Судалгаа, шинжилгээ туршилтад ашигласан халдварын сэжигтэй, халдвартай мал, амьтны сэг зэм гэх мэт хог хаягдал хамаарна.

Хүснэгт 2. Халдвартай хог хаягдал

Өнгө	Шар
Таних тэмдэг	"Био аюултай" таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.
Цуглуулах	<ul style="list-style-type: none"> Шингэн нэвчдэггүй, бат бөх, халуунд тэсвэртэй шар өнгийн уутанд цуглуулна. Хогийн савны $\frac{1}{4}$ хэмжээнээс хэтрүүлэлгүй хийнэ. Мэс заслын өрөөний хог хаягдлыг ажилбар бүрийн дараа өрөөнөөс гаргаж тур хадгалах байр руу зөөвөрлөнө.
Хаяглалт	Хог хаягдлын уутны гадна талд хаягжилт хийнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Тасаг, нэгжийн нэр Огноо

1.2.2. Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

Халдвартай эсэхээс үл хамааран хатгах, зүсэх гэмтэл учруулах эрсдэлтэй бүх төрлийн зүү, тариур, өндөг цоологч, наалдцын шил, мэс заслын хутга, ир, хагарсан ампул, түүнтэй адилтгах шилэн эд зүйл, пипетка, хуруу шил, лабораторийн гогцоо гэх мэт хурц үзүүр иртэй бүх төрлийн хог хаягдал хамаарна.

Хүснэгт 3. Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал

Өнгө	Шар
Таних тэмдэг	Аюулгүй хайрцгийн гадна талд 3/4 түвшинд "ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО" гэсэн анхааруулга бүхий хэвтээ шугам хэвлэгдсэн байх шаардлагатай.
Цуглуулах	<ul style="list-style-type: none"> Шингэн нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зузаан цаасан болон хуванцар зориулалтын "Аюулгүй хайрцаг"-т цуглуулна. Аюулгүй хайрцгийг суллаж, давтан хэрэглэхийг хориглоно. Аюулгүй хайрцгийг ашиглах явцад хог хаягдлыг хийхээс бусад тохиолдолд тагийг хаалттай байлгана. Тариурын зүүний тагийг эргүүлэн таглахгүй аюулгүй хайрцагт хийнэ Зүү мултлагчгүй аюулгүй хайрцагт (цаасан аюулгүй хайрцаг) тариураас зүүг салгалгүйгээр хийнэ. Зүү мултлагчтай хуванцар аюулгүй хайрцаг, зүү тайрагч, шатаагч хэрэглэсэн тохиолдолд тариурын ар талын хуванцар хэсгийг шар өнгийн халдвартай хог хаягдлын уутанд хийнэ. Аюулгүй хайрцгийг $\frac{1}{4}$ хэсгийг дүүрмэгц битүүмжилж, тур хадгалах цэг, байр руу зөөвөрлөнө. Нээж ашиглаж эхэлсэнээс хойш 1 сар болсон бол аюулгүй хайрцаг дүүрсэн эсэхээс үл хамааран тур хадгалах байр руу өгнө.

	<ul style="list-style-type: none"> Аюулгүй хайрцгийг түр хадгалах байр луу зөөвөрлөх хүртэл тасаг нэгж дотор түр хадгалах шаардлагатай бол "Био аюултай" таних тэмдэг бүхий таглаатай саванд хийж, цоожтой өрөө, эсвэл хүний хөл хөдөлгөөнөөс зайдуу газар, тусгай цэгт хадгална. Аюулгүй хайрцгийг ил задгай орхиж болохгүй. Аюулгүй хайрцгийг түр хадгалах байр хүртэл тагтай, бариултай "Био аюултай" таних тэмдэг бүхий саванд хийж зөөвөрлөнө. Энэ төрлийн хог хаягдлыг шахаж, нягтуулж болохгүй.
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> Тасаг, нэгжийн нэр Ашиглаж эхэлсэн огноо

1.2.3. Эмгэг хог хаягдал

Мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас, хүн, амьтны цогцос, эдийн шинжилгээний лааны тосон цутгамал, судалгаа шинжилгээнд ашигласан мал, амьтны сэг зэм зэрэг нь эмгэг хог хаягдалд хамаарна.

Хүснэгт 4. Эмгэг хог хаягдал

Өнгө	Шар
Таних тэмдэг	"ЭМГЭГ ХОГ ХАЯГДАЛ - БОЛГООМЖТОЙ ХАРЬЦАНА УУ" гэсэн анхааруулга савны гадна талд байршуулна. Шингэн нэвчдэггүй, бат бөх, халуунд тэсвэртэй шар өнгийн уут бүхий таглаатай саванд цуглуулна.
Савлах, цуглуулах	<ul style="list-style-type: none"> Утыг 3/4-аас дээш дүүргэхгүй. Утыг суллан дахин ашиглаж болохгүй.
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> Тасаг, нэгжийн нэр, Огноо
Хадгалах	<ul style="list-style-type: none"> Хөргүүрт бусад төрлийн хог хаягдаас тусад нь хадгална. Хөргүүртэй бол 72 цаг, хөргүүргүй бол 24 цагаас илүү хугацаанд хадгалж болохгүй. Шахаж, нягтуулж болохгүй.

1.2.4. Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, тун шил, хайрцаг зэрэг нь эмийн хог хаягдалд, хавдрын эмчилгээний үед хэрэглэгддэг эсэд хортой нөлөө үзүүлдэг эм, эмийн үлдэгдэл, тэдгээрийг агуулж байсан сав, тун шил, хайрцаг, хэрэглэсэн зүү, тариур зэрэг нь эсэд хортой эмийн хог хаягдалд хамаарна.

Хүснэгт 5. Эмийн болон эсэд хортой хог хаягдал

Өнгө	Хүрээнд
	Эмийн хог хаягдал
Эрсдэл	Хортой

Савлах Цуглуулах	<ul style="list-style-type: none"> Шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд цуглуулна. Хог хаягдлыг маягтын дагуу бүртгэж устгана. 	<ul style="list-style-type: none"> Шингэн нэвчдэггүй, бат бөх, хүрэн өнгийн уутанд цуглуулна. Зүү хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг ус нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, хуванцар аюулгүйн хайрцагт цуглуулж, битүүмжилсний дараа шингэн нэвчдэггүй, бат бөх хүрэн өнгийн уутанд хийнэ. Хог хаягдлыг маягтын дагуу бүртгэж устгана.
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааран тохирох таних тэмдэгтэй байна.	
Хаяглалт	<ul style="list-style-type: none"> Тасаг, нэгжийн нэр Хог хаягдал үүссэн огноо 	
Хадгалах	<ul style="list-style-type: none"> Бусад төрлийн хог хаягдалтай хольж болохгүй Энэ төрлийн хог хаягдлыг цуглуулах, савлах, устгах асуудлыг эмнэлгийн эм зүйн алба, баг хариуцна. 	

1.2.5. Химийн бодисын хог хаягдал

Химийн бодисын хог хаягдалд эруул мэндийн байгууллагын оношилгоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгах, халдвартуйжүүлэх үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай химийн бодисууд, хүнд металл агуулсан хэрэгслүүд хамаарна. Үүнд:

- Лабораторийн хаягдал (урвалж оношуулур, химийн бодисын хаягдал г.м.)
- Уусгагч,
- Рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал,
- Формальдегид, этилен оксид,
- Хугацаа дууссан химийн бодисууд,
- Шингэн хий агуулж байсан сав, бортого
- Хэрэглээнээс гарсан халууны шил, даралтын аппарат
- Эмнэлгийн зарим төрлийн багаж хэрэгсэл,
- Өдрийн гэрэл, зайд зэрэг болно (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Химийн бодисын хог хаягдал

Өнгө	ХҮРЭН
Эрсдэл	Химийн бодисын төрөл, шинж чанараас хамаарна
Савлах цуглуулах	<ul style="list-style-type: none"> Өөр өөр төрлийн химийн бодисын хог хаягдлыг хольж болохгүй. Химийн бодисын үлдэгдлийг цуглуулах савны 50 хувиас илүү дүүргэж болохгүй. Шингэн хог хаягдлыг битүүмжлэл бүхий тагтай, түгжээтэй саванд цуглуулах.
Таних тэмдэг	Хог хаягдлын шинж чанар, төрлөөс хамааруулан хортой, зэврэмтгий, исэл, шатамхай, холимог аюултай, хүрээлэн буй орчныг бохирдуулах материал, эсэд хортой г.м. тохирох таних тэмдэгтэй байна.

Хаяглалт	<ul style="list-style-type: none"> Тасаг, нэгжийн нэр Хог хаягдал үүссэн огноо Хог хаягдлын хэмжээ Химийн бодисын нэр, төрлийг бичих
Хадгалах, тээвэрлэх	<ul style="list-style-type: none"> Химийн бодисын төрөл, шинж чанараас хамааран хадгалах нэхцэл өөр өөр байна. Химийн бодисын хог хаягдал асгарч болзошгүй тул савыг шингэн цуглуулах тавиур дээр тавина. Хоорондоо урвалд орж болзошгүй химийн бодисын хог хаягдлыг тусад нь хадгална. Зөөх, тээвэрлэх нэхцэлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай саванд хийнэ.

1.3. Цацраг идэвхт хаягдал

Цацраг идэвхт хаягдалд эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, судалгааны явцад гарсан цаашид дахин хэрэглэгдэхгүй, цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн ионжуулагч цацраг бүхий цацраг идэвхт изотоп агуулсан, ямарч төлөв байдалд байж болох хаягдал хамаарна.

Хүснэгт 7. Цацраг идэвхт хаягдал

Эрсдэл	Цацраг идэвхт хаягдлыг физик, хими, цацраг, биологийн шинж чанараас нь хамааруулж ангилж, ялгах бөгөөд цацрагийн болон цацрагийн бус эрсдэлийг тооцоолно.	
Савлах цуглуулах	Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм"-д зааснаар цацраг идэвхт хаягдлыг физик, хими, цацраг, биологийн шинж чанараас нь хамааруулж ангилж, ялгах бөгөөд цацрагийн болон цацрагийн бус эрсдэлийг тооцоолж аюулгүй ажиллагааг хангана.	
Таних тэмдэг		<p>Олон улсын цацрагийн таних тэмдэгтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - 1, 2, 3 дугаар ангиллын үүсгүүр - 4, 5 дугаар ангиллын үүсгүүр <p>Ямар ч тохиолдолд тэмдгийг аюулгүй зайнаас таньж болохоор зургийн харьцааг хадгалсан байх бөгөөд хэмжээ нь түүнийг зүүх буюу наах төхөөрөмж, материалын овор хэмжээтэй зохицуулан хийж, аль болох тод хярагдахуйц байрлалд байрлуулж ашиглана. /MNS ISO 361:2001 стандарт/</p>
Хаяглалт	<p>Цацраг идэвхт хаягдлыг "Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм"-д заасны дагуу хаяглана.</p> <p>Хаягдлын контейнерт дараах мэдээллийг тэмдэглэнэ:</p> <ul style="list-style-type: none"> • цацраг идэвхт цөм; • хувийн дугаар; • цацраг идэвх, огноо. 	

Хадгалалт	<p>Цацраг идэвхт хаягдалтай холбоотой үйл ажиллагаанд "Цөмийн энергийн тухай" хууль, "Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрэм", "Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрэм" болон холбогдох норм, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллана.</p> <p>Цацраг идэвхт шингэн хаягдал тухайлбал эмчилгээний өндөр тунгаар цацраг идэвхт изотопыг хэрэглэсэн өвчтөнүүдээс гарч буй өтгөн, шээс зэрэг биологийн шингэнийг төвлөрсөн бохир усны шугамд хаяхын өмнө хамгаалалттай саванд хяналтаас чөлөөлөх түвшин хүртэл хадгална.</p>
-----------	--

--о0о--

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
08 сарын 01 өдрийн 09:00 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ
ТЭЭВЭРЛЭХ ЗААВАР**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг нийтийн эзэмшлийн зам талбайгаар, тээврийн хэрэгсэл ашиглан тээвэрлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх болон аюултай хог хаягдлыг шуудан, агаар, усан замаар тээвэрлэхэд энэхүү заавар хамаarahгүй бөгөөд тэдгээр нь олон улс болон дотоодод мөрдөгдөж буй дүрэм, зааврын хүрээнд зохицуулагдана.

1.3. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хөдөлгөөний ачаалал бага цагт, тогтоосон маршрутын дагуу тээвэрлэнэ.

Хоёр. Хог хаягдлыг баглах, хаяглах

2.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх нөхцөл, замын чичиргээ, температурын өөрчлөлт, чийгшил, даралт зэргээс хамаарч доторх зүйл асгарч гоожихгүй байхаар тээвэрлэхийн өмнө сайтар баглана.

2.2. Тээвэрлэлтэд бэлтгэсэн аюултай ачаа нь зориулалтын сав, баглаа боодлой, стандартын шаардлага хангасан хаяг, шошготой байна.

2.3. Багласан хог хаягдлыг зориулалтын бат бэх, амархан цоорохооргүй, нүх сувгүй, шингэн нэвчихгүй, таглаатай хуванцар даванд хийж гадна талд нь Хүснэгт 1-д үзүүлсний дагуу НҮБ-аас баталж гаргасан тусгай тэмдэглэгээг байрлуулна.

Хүснэгт 1. Аюултай хог хаягдлын баглаа боодлын тэмдэглэгээ


	4H2/Y94/S/08/MGL/001
	Жин: 94 кг

Энэхүү тэмдэглэгээ нь дараах агуулгатай:

UN	НҮБ-ын баглаа боодлын тэмдэглэгээ		
4H2	Баглаа боодлын төрлийг тодорхойлно:		
	Эхний тоо (4)	Хоёр дахь үсэг (H)	Гуравд х тоо (2)
	1 – Торх	A – Ган	1 – Салдаг таг
	2 – Төмөр торх	B – Хөнгөн цаг ан	2 – Салдаггүй, бэхэлгээтэй таг
	3 – Лааз	C – Цаасан хайрцаг	
	4 – Хайрцаг	D – Хуванцар	
	5 – Цүнх	E – ...	
	4H2 = Салдаггүй, бэхэлгээтэй тагтай хуванцар хайрцаг		
Y94	Y = II болон III бүлэгт хамаарах халдвартай зүйлс 94 = Хатуу биет: Баглаа боодол дахь зүйлсийн жин нь 94 кг		

S	Зөвхөн хатуу биетэд хэрэглэнэ: S = Хатуу биет.
08	Хог хаягдлыг багласан тухайн оны сүүлийн 2 орныг илэрхийлнэ: 08=2008
MGL	MGL = Монгол улс
001	Хог хаягдлыг тээвэрлэж буй байгууллагын код

2.4. Аюултай хог хаягдал тээвэрлэх савны гадна талд 100 мм x 100 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 5 мм байна) "Био аюултай" таних тэмдгийг тавьж, доод өнцөт нь НҮБ-ын эмнэлгийн хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд "Халдвартай эд зүйл" гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно (Зураг 1).



Зураг 1. Аюултай хог хаягдал тээвэрлэх савны гадна талын таних тэмдэг

2.5. Хог хаягдлын савны таних тэмдэг нь уншигдахуйц ил тод, ойлгомжтой, цаг агаарын аливаа үзэгдлийн нөлөөгөөр арилахааргүй байна.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тээвэрлэлт, тээвэрлэх тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага

3.1 Эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.2 Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан аюултай хог хаягдлыг нийтийн эзэмшлийн замаар тээвэрлэхэд тавигдах (UN 3291) шаардлагын дагуу эмнэлгийн хог хаягдлыг тээвэрлэнэ.

3.3 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь замын хөдөлгөөнд оролцох шаардлага бүрэн хангасан, тусгай таних тэмдэгтэй, аюулгүй ажиллагааны заавар хангасан (Зураг 2), битүүмжлэгдсэн, тусгайлан тоноглогдсон, хөргүүртэй, Авто тээврийн асуудал эрхэлсэн байгууллагаас тухайн төрлийн аюултай ачаа тээвэрлэхэд ашиглаж болох тухай тодорхойлолттой зориулалтын тээврийн хэрэгсэл байна.

3.4 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг цуглуулах чиглэл болон цагийн хуваарийг замын хөдөлгөөний хэв маяг, гудамж талбайн зохион байгуулалт, аюултай хог хаягдал цуглуулах байгууламж нь замын аль талд байрласан зэрэг хүчин зүйлсийг авч үзэн холбогдох мэргэжлийн байгууллагатай урьдчилан тохиролцож, тогтоосон зам /маршрут/-ын дагуу тээвэрлэнэ.

3.5 Аюултай хог хаягдлыг тээвэрлэгч байгууллага нь эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд үүсэж буй хог хаягдлын хэмжээ, улирлаас шалтгаалж тээвэрлэх давтамжийг гэрээнд тусгасан байна.

3.6 Аюултай хог хаягдлыг тээвэрлэж дууссаны дараа тухайн тээврийн хэрэгслийг аюулгүй, хоргүй, халдвартгүй болгох арга хэмжээг авна.

3.7 Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл дараах шаардлагыг хангана. Үүнд:

3.7.1 Жолоочийн кабин болон ачааны хэсэг хоорондоо тусгаарлагдсан байх;

3.7.2 Машины дотор тал нь цэвэрлэж халдвартгүйжүүлэх боломжтой байх;

3.7.3 Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршигийг арилгах зориулалтын багаж, гол түймэр унтраах хэрэгсэл /гальян хор, хурз, шуудайтай элс, хувин г.м/;


3.7.4 Шингэн зүйлс гоожиход авах арга хэмжээний заавар, цэвэрлэх хэрэгсэл, халдвартгүйжүүлэгч бодис, хоосон нийлэг уут, бээлий, амны хаалт, шингээгч алчуур, хурз зэрэг цэвэрлэгээний багаж;

3.7.5 Хор саармагжуулах бодис, уусмал, яаралтай тохиолдолд хэрэглэх засварын хэрэгсэл;

3.7.6 Машины хүндийн жин, дугуйны хэмжээнд тохирсон зогсоогч (механик тоормоз);

3.7.7 Цахилгаанаас хамааралгүй асдаг 2 ширхэг шар гэрэл зэрэг болно.


3.8. Тээврийн хэрэгслийн гадна талд 250 мм x 250 мм-ээс багагүй ромбо хэлбэрийн дүрстэй, ижил өнгийн давхар хүрээтэй (дотор талын хүрээний өргөн 12,5 мм байна) "Био аюултай" таних тэмдгийг тавьж, доод өнцөгт нь НҮБ-ын эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг илэрхийлсэн 25 мм-ийн өндөртэй 6 гэсэн тоог бичнэ. Тус таних тэмдгийн дотор талд "Халдвартай эд зүйл" гэсэн тэмдэглэгээ байрлуулж болно (Зураг 2).



Зураг 2. Тээврийн хэрэгслийн таних тэмдэг

3.9. Тээврийн хэрэгслийн урд болон ар талд галд тэсвэртэй материалаар хийгдсэн, улбар шар өнгөтэй 400 мм өргөн, 300 мм өндөр, 15 мм өргөнтэй хар өнгийн хүрээтэй анхааруулах тэмдгийг байрлуулна. Түүн дотор НҮБ-ын "аюул"-ыг илэрхийлсэн

606 болон 3291 дугаар бүхий тэмдэглэгээг 10 см-ын өндөр, 15 мм-ын өргөнтэйгөөр, хар өнгөөр бичнэ (Зураг 3). Тээврийн хэрэгслийн овор хэмжээнээс хамааран урд талын анхааруулах тэмдгийн өргөнийг 300 мм, өндрийг 120 мм, хүрээний өргөнийг 10 мм болгон багасгаж болно.



Зураг 3. Тээврийн хэрэгслийн анхааруулах тэмдэг

3.10. Жолооч тээвэрлэлтэд гарахын өмнө тээврийн хэрэгслийн шалгах хуудсыг бөглөж (Хүснэгт 3), тээвэрлэх үйл ажиллагаа дууссаны дараа жолооч эмнэлгийн хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгнө.

Хүснэгт 3. Тээврийн хэрэгслийн шалгах хуудас

А. Тээврийн хэрэгслийн техникийн шалгалт	Шалгасан (5 өдөр)				
	1	2	3	4	5
1. Тоормос ажиллагаатай					
2. Дугуйн хээ гүн, тод					
3. Дугуйны хий хангалттай					
4. Толь болон цонх цэвэр					
5. Шил арчигч ажиллагаатай					
6. Гэрэл болон мэдээллийн самбар ажиллагаатай					
7. Тээврийн хэрэгслийн гадна талд гэмтэл байхгүй					
В. Хамгаалах хэрэгсэл					
8. ABC Гал унтраагчтай, гал унтраагч ажилладаг					
9. Анхны тусламжийн хайрцагтай					
10. Асгарч, гэмтэхэд авах арга хэмжээний багаж хэрэгсэл бүрэн: Шингээгч материал, хүрз, 2 ш шар уут, халдвартгүйжүүлэх бодис, бээлий					
11. Аюулгүй ачиж, буулгах, тээвэрлэх хэрэгслүүд					
12. Анхааруулах гурвалжин тэмдэг					
13. Анхааруулах тэмдэг харагдахуйц тод, харагдахуйц байрлалтай					
С. Баримт бичиг					
14. Жолоочийн үнэмлэхтэй					
15. Хог хаягдлын хүлээлцэх бүртгэлийн маягт					
16. Баглаа боодлын таних тэмдэг, тэмдэглэгээтэй					
17. Эрсдэлийг бүртгэх хуудас					

Он сар болон гарын үсэг				
1 дэх өдөр: Он сар / Гарын үсэг		—		
2 дахь өдөр: Он сар / Гарын үсэг		—		
3 дахь өдөр: Он сар / Гарын үсэг		—		
4 дэх өдөр: Он сар / Гарын үсэг		—		
5 дахь өдөр: Он сар / Гарын үсэг		—		

Тусгай тэмдэглэгээ

Дөрөв. Тээвэрлэлтийн үеийн ажилтны аюулгүй байдал

4.1. Аюултай хог хаягдлыг тээвэрлэгч байгууллага нь тээвэрлэлт хийх жолоочийг сургалтад хамруулж аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюултай ачаа тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулсан байна. Эдгээр баримт бичиг болон тээвэрлэлтийн гэрээ /ачаа дагалдах бичиг/, замын хуудсыг жолооч заавал биедээ авч явна.

4.2. Хог хаягдлыг тээвэрлэх явцад аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул, эрсдэлээс сэргийлэх үүргийг тээвэрлэгч хүлээнэ.

4.3. Хог хаягдлын хайрцаг, сав нь гэмтэлтэй, авто тээврийн хэрэгсэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.

4.4. Тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага ажилтнаа хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж, хэрэглээнд хяналт тавина.

4.5. Ажилтныг тархвар судлалын заалтаар болон сайн дурын үндсэн дээр В гепатитын эсрэг дархлаажуулалтад хамруулна.

4.6. Ажилтныг аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэхтэй холбогдсон аргачлал, арга зүйн чиглэлийн сургалтад тогтмол хамруулна.

4.7. Тээвэрлэгч нь гал унтраах хэрэгслийг ашиглах талаар мэдлэгтэй байх бөгөөд тээврийн хэрэгсэл дотор болон ойр орчимд тамхи татахыг хориглоно.

4.8. Тээвэрлэлтийн үед, ачиж, буулгах явцад ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдооос сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлсэн байна. Аюултай хог хаягдал бүхий баглаа боодол, уут сав, хайрцаг зэргийг нээж үзэхийг хориглоно.

4.9. Аюултай ачаатай авто тээврийн хэрэгслийг хот, суурин газарт зориулалтын бус гарааш, зогсоолд тавихыг хориглоно.

Тав. Аюултай хог хаягдлын тээвэрлэлтийн явцад үүсэх

эрсдэлийн үеийн хариу арга хэмжээ

5.1. Үүссэн нөхцөл байдлын эрсдэл, хор хөнөөлд тохирсон хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.2. Жолооч осол аваарын талаарх байгууллагын хог хаягдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтанд маягтын дагуу (Хүснэгт 4) мэдээлнэ.

5.3. Ажилтан цусаар дамжих халдварт авах эрсдэлд өртсөн бол эрсдэлийг бууруулахын тулд өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг халдвараас сэргийлэх арга хэмжээний зааврын дагуу хэрэгжүүлнэ.

5.4. Аюултай хог хаягдал тээвэрлэгч байгууллага нь осол гэмтлийг бүртгэн хор хохирол учруулсан шалтгааныг нь тогтоосон дун шинжилгээ хийж хариу арга хэмжээ хэрэгжүүлж ажиллана.

5.5. Нийтийн эзэмшлийн зам талбайд аюултай хог хаягдал асгарч гоожсон болон осол гарсан тохиолдолд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

5.5.1. Хог хаягдал унаж уутнаасаа асгарч гоожсон үед давхар уутанд хийж зам талбайг халдвартгүйжүүлнэ. Сав нь гэмтсэн бол давхар саванд хийх эсвэл өөр саванд зөөн шилжүүлнэ.

5.5.2. Шингэн хог хаягдал бага хэмжээтэй гоожсон үед нэг удаагийн алчуур, самбай тавин халдвартгүйжүүлэх бодисоор халдвартгүйжүүлсний дараа шингээж авах ба их хэмжээтэй бол элс, хөрс эсвэл өөр материалд шингээн авч шар уутанд цуглувуна.

5.5.3. Хэрвээ эд зүйлс усны эх үүсвэр, шугам хоолойд орсон бол холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

5.5.4. Аюултай хог хаягдал шатсан тохиолдолд гал унтраагч ашиглан галыг түргэн унтраана, шатаагүй эд зүйлсийг галаас түргэн холдуулна. Шаардлагатай тохиолдолд галын тусламжийн дуудлага өгнө.

5.5.5. Химийн бодист хордох эрсдэл үүссэн үед эрсдэлийн мэдээллийг иргэдэд яаралтай өгч, эрсдэлтэй газраас хол байх санамж анхааруулга өгч Онцгой байдлын тусламжийн утсанд мэдээлж, хариу арга хэмжээ авна.

5.5.6. Шаардлагатай тохиолдолд аюултай хог хаягдлын тээвэрлэлтийн явцад үссэн осол гэмтэл, эрсдэлт нөхцөлд мэргэжлийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

5.6. Эрсдэлт нөхцөл байдал үүссэн үед ажиллаж байгаа ажилтан хамгаалах хувцас хэрэгсэл өмсөнө.

Хүснэгт 4. Аюултай хог хаягдлын эрсдэлийг буртгэж мэдээлэх хуудас

№	Хугацаа /он, сар, өдөр, цаг, минут/	Тээврийн хэрэгслийн марк, дугаар	Жолпоочийн овог нэр, утасны дугаар	Эрсдэлтүүссэн газар	Эрсдэлийн тухай мэдээлэл	Авсан арга хэмжээ	Мэдээлсэн албан тушаалтан, албан газар	Эрсдэлийн үнэлгээний мэдээлэл	Бусад мэдээлэл	Эрсдэлтийг буртгэсэн хүний гарын үсэг
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										

---оо---

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
05 сарын 01 өдрийн 14:13 дугаар
тушаалтын гуравдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЮУЛТАЙ
ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгахдаа энэхүү зааврыг мөрдөнө. Аюултай хог хаягдлын устгахдаа байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байх, зөвшөөрөгдсөн аргаар боловсруулалт, устгал хийнэ.

1.2. Хуванцар болон нийлэг материалыаар хийгдсэн гялгар уут, сав, тариур зэрэг хог хаягдал, эмийн шил, сав зэргийг цуглуулан үйлдвэр, аж ахуйн нэгжид хоёрдогч түүхий эдээр өгч дахин ашиглуулах бол халдвартай хог хаягдлын ангилалд багтах хог хаягдлыг халдвартайжүүлж аюулгүй болгож өгнө.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь аюултай хог хаягдлыг боловсруулах устгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тусгай зөвшөөрөлтэй төвлөрсөн байгууламжтай газар гэрээ байгуулан хог хаягдлаа устгунна.

1.4. Аюултай хог хаягдал боловсруулах, устгах төвлөрсөн байгууламжгүй газарт аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах хэсгийн байгууламжийг байгуулан боловсруулалт, устгал хийнэ.

1.5. Хог хаягдал боловсруулах төвлөрсөн байгууламжгүй аймаг, сум, суурин газарт аюултай хог хаягдлыг боловсруулах устгах зөвшөөрөгдсөн аргаар боловсруулалт, устгал хийнэ.

1.6. Хэсгийн байгууламжид аюултай хог хаягдлыг боловсруулж, устгаж буй эрүүл мэндийн байгууллага нь аюултай хог хаягдлыг буталж жижиглэн овор хэмжээг багасгах, халдвартайжүүлэх тоног төхөөрөмжтэй байна.

1.7. Хэсгийн байгууламж нь аюултай хог хаягдлын боловсруулалт, устгал хийх боломжтой өрөө тасалгаа, зам талбайтай, тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, ашиглах техникийн нөхцөлийг хангасан байна.

1.8. Хог хаягдал боловсруулах төвлөрсөн болон хэсгийн байгууламжгүй сум, тосгоны эрүүл мэндийн байгууллага нь аюултай хог хаягдлыг халдвартайжүүлж, эмнэлгийн хогийн цэгт булж устгах нөхцөлөөр хангагдсан байна. Эсхүл байгууламж бүхий газартай гэрээ байгуулан устгунна.

1.9. Хэсгийн байгууламжид устгах, боловсруулалт хийх боломжгүй аюултай хог хаягдлыг зөвшөөрөл бүхий төвлөрсөн байгууламжтай газарт устгунна.

1.10. Эмийн, эсэд хортой нөлөөтэй, химийн хог хаягдлыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөвшөөрөл бүхий төвлөрсөн байгууламжид гэрээгээр устгунна.

1.11. Аюултай хог хаягдлыг ил задгай, утааны шүүгчгүй зориулалтын биш зууханд, хүн амын суурьшлын бус болон хогийн цэгт шатааж устгахыг хориглоно.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах нийтлэг аргууд

2.1. Халуун, өндөр даралттай уураар халдвартайжүүлэх - Автоклав ашиглан өндөр даралтат эсвэл вакум халуун, чийгтэй уураар халдвартай, хурц үзүүр иртэй хог хаягдлыг халдвартайжүүлнэ.

2.1.1. Автоклав тус бүрийн ажиллах зааврыг баримтална. Хог хаягдлыг автоклавт 121°C-ийн хэмд 20 минут, 134°C-ийн хэмд 10 минутын хугацаанд халдвартай жуулна.

2.1.2. Автоклавт "Pyrex" халуунд тэсвэртэй шил, полипропилен (PP) болон полиэтилен (PE) гэх мэт халуунд тэсвэртэй хуванцар, ган төмрөөр хийгдсэн савыг хэрэглэнэ.

2.1.3. Нийлэг ууттай хог хаягдал, латекс, винил, цаас, хуванцар соруурын хошуу, өсгөврийн аяга зэргийг зориулалтын сав, сагсанд хийж автоклавт халдвартай жуулна.

2.1.4. Уусгагч, ууршимтгай, хлорт нэгдлүүд (HCL, цайруулах) буюу идэмхий химийн бодис (тухайлбал: фенол, гурван хлорт цууны хүчил, эфир, хлороформ), эсэд хортой нөлөөтэй хог хаягдал, түүгээр бохирдсон материал, цацраг идэвхт материал, зарим хуванцар, хүнд металлын хог хаягдлыг автоклавт хийхийг хориглоно.

2.2. Буталж, жижиглэн өндөр даралттай уураар халдвартай жуулэх – Хог хаягдлын бутлагчтай автоклав. Хог хаягдлыг буталж, өндөр даралттай халуун уураар халдвартай жуулэх горимтой.

2.2.1. Үйлдвэрлэгчийн зааврыг мөрдөнө. Тохирох хог хаягдлыг боловсруулна. Халдвартай жуулж бутлах төхөөрөмжид үйлдвэрлэгчийн зааварт заасан хог хаягдлыг хийнэ.

2.2.2. Нэг мечлэгт халдвартай жуулж бутлах хог хаягдлын хэмжээг төхөөрөмжийн хүчин чадалд тохируулан тооцно.

2.2.3. Бутлах төхөөрөмжид зузаан ган, титан, металл эд зүйлс, сүлжмэл эдлэл, эмгэг, эмийн болон эсэд хортой, хүнд металл, цацраг идэвхт, химийн бодис зэрэг хог хаягдлыг хийхийг хориглоно.

2.3. Буталж, жижиглэн бичил долгиноор халдвартай жуулэх – Бичил долгион нь усыг богино хугацаанд халааж дулааны нөлөөгөөр халдвартай жуулдэг. Нэг мечлэгийн хугацаа ойролцоогоор 20 минут орчим, тоног төхөөрөмж бүрийн үйлдвэрлэгчийн зааврыг баримтална. Хог хаягдлыг буталж, жижиглэсэн байх шаардлагатай байдаг.

2.4. Химийн бодисоор халдвартай жуулэх- Химийн бодисын халдвартай жуулэх нөлөөг ашиглах хог хаягдлыг халдвартай жуулна.

2.5. Агаарын шүүлтүүртэй, зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатаах

2.5.1. Эрүүл мэндийн байгууллагын халдвартай, хурц иртэй, үзүүртэй, эмгэг, зарим төрлийн эмийн болон эсэд хортой хог хаягдлыг зориулалтын шатаах зууханд шатааж устгана.

2.5.2. Шатаах зуух тус бүрийн үйлдвэрлэгчийн зааврыг баримтлан ажиллуулна.

2.5.3. Шатаах зуух нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Шатаах зуух нь газ, дизель түлшээр ажиллах боломжтой, түлшээр тасралтгүй хангах төхөөрөмжтэй, түлш нөөцлөх савтай, цагт 50 килограммаас доошгүй хог хаягдлыг шатаах хүчин чадалтай байна.

- Хоёр камертай байна. Камер бүр агаар болон түлшээр тасралтгүй хангах эх үүсвэрт холбогдсон байх бөгөөд агаар, дулааны автомат мэдрэгчтэй, анхдагч болон хоёрдогч камерын дулаан бууралтыг мэдрэгч нь дуут болон гэрлэн дохио өгөх төхөөрөмжтэй байна.

- Зуухны камерын дотор тал нь 1400 хэмд тэсвэртэй материалаар хийгдсэн, гадна талын гадаргуугийн халалт 50-55 хэмээс ихгүй байх шаардлагатай ба термометр суурилуулсан байна.

- Автомат тохируулгатай, хяналтын дэлгэцтэй байна. Агааржуулалтын автомат тохируулгатай байна.

2.5.4. Аюултай хог хаягдлыг шатааж устгаж байгаа байгууламжид гадны хүн орохыг хориглоно. Аюулгүй ажиллагааны заавар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө, зааврыг нүдэнд ил харагдахуйцаар бичиж хананд байрлуулсан байна.

2.5.5. Шатаах зуухыг ажиллуулах ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, хог хаягдлын менежментийн сургалтад хамрагдсан байна.

2.5.6. Ажилтан нүүрний хамгаалалт, дулаанд тэсвэртэй бээлий, ажлын гутал гэх мэт хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангагдсан байх бөгөөд шаардлагатай хэрэгслийг зөв хэрэглэнэ.

2.5.7. Шатаах зуухны хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж бүртгэл хөтлөн, хэвийн үйл ажиллагааны алдагдал гарсан тохиолдолд засвар үйлчилгээний хэсэгт цаг алдалгүй мэдэгдэнэ.

2.5.8. Шатаах зууханд хог хаягдлыг хийх, шатаах, үнсийг зайлцуулах, ойр орчмыг цэвэр байлгах үүрэгтэй.

2.5.9. Зууханд хог хаягдлыг шатаах:

- Зууханд шатаах хог хаягдлын чийглэг 30 хувиас ихгүй, шатах материалын агууламж 60 хувиас их байна.

- Зуухны анхдагч камер дахь дулаан 850 хэмээс багагүй, хоёрдогч камер дахь дулаан 1100 хэмд хүрсэн нөхцөлд зууханд хог хийх системийг ажиллуулж, хогийг тохирох хэмжээгээр хийнэ.

- Хог хаягдлыг камер тус бүрд 2 секундээс доошгүй хугацаанд, бүрэн шатаж дуустал байлгана.

- Зуухны үнсийг тусгай зориулалтын тагтай саванд цуглуулж хадгалах бөгөөд зориулалтын ландфилд устгана.

- Зуухны бохирдлыг цэвэрлэхэд ашигласан бохир ус болон тортгийг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл саармагжуулсны дараа төвлөрсөн бохирын шугамд нийлүүлнэ.

- Шатаах зуухнаас ялгарч буй утаа, үнсэнд 3 сар тутамд чанарын хяналт хийнэ.

2.5.10. Хог хаягдлыг шатаахад дараах зүйлийг хориглоно. Үүнд:

- Зуухан дахь хог хаягдал бүрэн шатаагүй тохиолдолд нэмж хийхийг хориглоно.

- Шатаах зуухан дахь халуун зохих хэмжээнд хүрээгүй, агаар хөргөлтийн сэнс, дэлгэц, агаарын бохирдлын хяналтын систем доголдолтой эсвэл хэт халуун байх үед шатаах зууханд хог хаягдлыг хийж болохгүй.

- Даралтат сав, ихээхэн хэмжээний химийн бодис, урвалж, мөнгөний давс, фото химийн болон цацраг идэвхт бодис, мөнгөн ус, кадми агуулсан хэрэгсэл, дэлбэрэх аюултай зүйлс, хлор бүхий химийн бодис бүхий зүйлсийг шатааж устгахыг хориглоно.

2.5.11. Агаарын бохирдлын хяналтын систем суурилаагүй шатаах зуух ашиглахыг хориглоно.

2.6. Капсулдах арга - Эмийн болон эсэд хортой хог хаягдлыг төмөр саванд 50 хувь хүртэл хортой эмийг, 15:15:5 харьцаатайгаар цемент, шохой, усыг сайтар хольж дүүргэн савны тагийг гагнаж лацдан 7-28 өдрийн дараа газарт булж, дээрээс нь шингэн нэвчихгүй шавар давхарга хийнэ.

2.7. Ландфилл - Байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр газарт булшилж, хадгалах байгууламжийг хэлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах

3.1. Халдвартай хог хаягдлыг боловсруулах, устгах

3.1.1. Халдвартай хог хаягдлыг боловсруулах, устгахаас булах эсхүл агаарын шүүлтүүртэй, зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгана.

3.1.2. Хог хаягдлыг автоклавт өндөр даралттай уур эсвэл бичил долгионы аргаар халдвартай хог хаягдлыг эрсдэлгүй болгосны дараа ландфиллийн аргаар булж устгана.

3.1.3. Зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгаж байгаа бол халдвартай хог хаягдлыг эсхүл шаардлагагүй шууд шатааж устгана.

3.1.4. Био аюулгүй ажиллагааны 2-4 дүгээр зэрэглэлийн лабораториос үүсэх амьд үүсгэгч агуулсан ёсгөвөр, тэжээлт орчин, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үед үүссэн хог хаягдлыг үүссэн цэгт нь автоклавт халдвартай хог хаягдлыг түр хадгалах байр руу шилжүүлнэ.

3.1.5. Аюултай хог хаягдлыг боловсруулах, устгах төвлөрсөн байгууламжтай газарт 3.1.4-т зааснаас бусад халдвартай хог хаягдлыг халдвартай хог хаягдлыг эсхүл шаардлагагүй шууд илгээнэ.

3.1.6. Халдвартай шингэн хог хаягдлыг боловсруулах, устгах

- Лабораториос гарч буй цус, сийвэн, нугасны ус, шээс, өтгөн гэх мэт биологийн шингэнийг урьдчилан халдвартай хог хаягдлыг боловсруулах, зориулалтын шугам буюу шаардлага хангасан бохирын цооногт хийнэ.

- Идэвхтэй хэлбэрийн сурьеэтэй өвчтөний цэрийг тусад нь тагтай саванд цуглуван. Өндөр даралттай уур эсхүл химийн аргаар халдвартай хог хаягдлыг эсхүл шаардлагагүй шууд илгээнэ.

- Савлагаатай цус, цусан бүтээгдэхүүнийг халдвартай хог хаягдлын нэгэн адил устгана. Бүтээгдэхүүний сав баглааг задалж устгах шаардлагагүй.

3.1.7. Вакцин, био бэлдмэлийг боловсруулах, устгах

- Хадгалалтын хугацаа дууссан, задалснаас хойш ашиглах боломжгүй болсон үлдэгдэл вакцин, био бэлдмэлийг халдвартай хог хаягдал цуглуван зориулалтын уут, ампултай вакцины үлдэгдэл, ампулыг аюулгүй хайрцагт цуглуван түр хадгалах байр руу илгээнэ.

- Вакцин био бэлдмэлийг автоклавт халдвартгүйжүүлж устгана. Шатаах арга ашиглаж байгаа бол шууд шатааж устгана.
- Вакцины савлагааг задлан халдвартгүйжүүлэх уусмалд хийхийг хориглоно.
- Устгасан вакцин био бэлдмэлийн хүн тун, тоо хэмжээг "Вакцин, био бэлдмэлийн зарцуулалтын маяг"-д бүртгэнэ.
- Их хэмжээгээр устгах тохиолдолд вакцин био бэлдмэлийн нэр, тоо хэмжээ, хүн/тун, цувралын дугаар, устгалын шалтгаан, устгасан арга, устгал хийсэн бүрэлдэхүүн зэрэг мэдээллийг тусгасан тэмдэглэл үйлдэнэ.

3.2. Хурц үзүүр, иртэй хог хаягдлыг боловсруулах, устгах

3.2.1. Халдвартай хог хаягдлын нэгэн адил агаарын шүүлтүүртэй, зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгах эсхүл автоклав, бичил долгиноор халдвартгүйжүүлж, буталж ландфилдэж устгана.

3.2.2. Халдвартгүйжүүлсний дараа тусад нь цуглуулан хоёрдогч түүхий эд болгон өөр зориулалтаар ашиглаж болно.

3.3. Эмгэг хог хаягдлыг устгах

3.3.1. Төвлөрсөн байгууламжид агаарын шүүлтүүртэй, зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгах эсхүл халдвартын эрсдэлгүй бол орон нутагт эхэсийн нүхэнд хийнэ.

3.3.2. Халдвартын эрсдэлгүй эмгэг хог хаягдлыг эхэсийн нүхэнд хийж устгаж байгаа бол газрын хөрсөнд задрах хугацааг удаашруулах тул гадуур нь уут, сав ашиглахгүй, ямар нэгэн халдвартгүйжүүлэх бодис хийх шаардлагагүй.

3.3.3. Зоонозын халдвартын үед судалгаа, шинжилгээнээс үлдсэн мал амьтны сэг зэмийг өндөр хэмд шатааж эсхүл булж устгана. Бoom, үр үүсгэдэг нянгаар үүсгэгдсэн халдвартын үед үүсэх эмгэг хог хаягдлыг булж устгахыг хориглоно.

3.3.4. Аймаг, орон нутгийн зоонозын өвчин судлалын төвүүд нь төвлөрсөн байгууламж байхгүй, зориулалтын шатаах зуухгүй бол тандалт, оношилгоо, судалгаа шинжилгээний явцад үүссэн эмгэг хог хаягдлыг булшлах нүхтэй байна.

3.3.5. Булшлах нүх нь тус зааврын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан "Эхэсийн нүхэнд тавигдах шаардлага"-ыг хангасан байна.

3.3.6. Булшлах нүх нь усны сан, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүсээс гадагш 2 км-ээс доошгүй зйттай байна. Булшилсан газарт "АНХААР" гэсэн анхааруулга тэмдэг байршуулж, газрын нэр болон байршлыг газар зүйн байршил тогтоогч багажаар (GPS) тэмдэглэнэ.

3.3.7. Тандалт, судалгаа, шинжилгээнээс үлдсэн мал, амьтны сэг зэмийг автоклав, бичил долгион болон халдвартгүйжүүлэх уусмалаар халдвартгүйжүүлэхийг хориглоно.

3.4. Эмийн болон эсэд хортой хог хаягдлыг боловсруулах, устгах

3.4.1. Агаарын шүүлтүүртэй, зориулалтын шатаах зууханд өндөр хэмд шатааж устгах, үnsийг ландфилдэх эсхүл капсулдах аргаар устгана.

3.4.2. Хадгалалтын хугацаа дууссан, тээвэрлэлтийн явцад сав баглаа, боодол гэмтсэн, хэрэглээний шаардлага хангахгүй болсон эмийн болон эсэд хортой хог хаягдлыг тухайн орон нутагт боловсруулах, устгах боломжгүй тохиолдолд үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, хандивлагчид эргүүлэн буцаана. Буцаан татан авалт хийсэн

дотоодын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, хандивлагч нар өөрсдийн зардлаар эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг боловсруулах төвлөрсөн байгууламжид өгч устгуулна.

3.4.3. Хортой эмийг шууд газарт булах, бохир усны шугам хоолойд хийх, тун шилийг бяцлах, автоклавдахыг хориглоно.

3.4.4. Хоргүй эмийн бодис тухайлбал, витамин, давс, глюкозын уусмал, нүдний дусаалга гэх мэтийг бохирын шугамд асгаж болно.

3.4.5. Зориулалтын шатаах зуухгүй бол хортой эмийг капсулдах аргаар устгана. Капсулдах арга - Төмөр саванд 50 хувь хүртэл хортой эмийг, 15:15:5 харьцаатайгаар цемент, шохой, усыг сайтар хольж дүүргэн савны тагийг гагнаж лацдан 7-28 өдрийн дараа газарт булж, дээрээс нь шингэн нэвчихгүй шавар давхарга хийнэ.

3.5. Химийн бодисын хог хаягдлыг устгах

3.5.1. Хог хаягдлаас хамаарч өөр өөр устгах арга ашиглана. Шингэн химийн хог хаягдлыг саармагжуулж, хоргуйжүүлнэ. Төвлөрсөн байгууламж руу тээвэрлэж устгал хийлгэнэ.

3.5.2. Рентген зураг авахад ашиглаж байгаа тодруулагч болон бэхжүүлэгч уусмалыг шууд бохирын шугамд хийхийг хориглоно. Тусад нь цуглуулж ханган нийлүүлэгч рүү буцаана.

3.5.3. Халдвартгүйжүүлэх, ариутгах зэрэг химийн бодисыг хоргуйжүүлж, саармагжуулж устгана. Бодис тус бурийн устгах зааврыг баримтална.

Дөрөв. Эхэсийн нүхэнд тавигдах шаардлага, ашиглах заавар

4.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг боловсруулах байгууламж байхгүй газарт буюу хөдөө орон нутагт мэс ажилбар, задлан шинжилгээний явцад гарсан биеийн хэсэг, тайрсан эд эрхтэн, хавдрын ургацаг, эхэс, зулбадас, хүн, амьтны цогцос, эдийн шинжилгээний лааны тосон цутгамал зэргийг эхэсийн нүхэнд хийнэ.

4.2. Эхэсийн нүхэнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

4.2.1. Эхэсийн нүх нь ашиглалтын явцад ил задгай болон гүний усны эх үүсвэр, хөрс агаарыг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан байна.

4.2.2. Усны эх, ундарга, нөөцийг бохирдооос хамгаалах зорилгоор үерт автхааргүй, хөрсний элэгдэлгүй газарт газрын гүний уснаас 2 м-ээс дээш түвшинд байрлана.

4.2.3. Эмнэлгийн хашаан дотор, эмнэлгийн барилгаас 5-15 метр, ус түгээх цэгийн байрнаас 20 метр, өрөмдмөл худгаас 150-250 метр, голын эргээс 200-250 метрээс багагүй зайд, тухайн газар нутгийн зонхилох салхины чиглэлийн доод талд байрлана.

4.2.4. Эмнэлгийн хашаанд байрлуулах боломжгүй тохиолдолд эхэсийн нүхэнд тавигдах шаардлагыг хангасан газрыг мэргэжлийн байгууллагатай зөвшилцэж сонгоно. Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайгаар хангагдсан байна.

4.2.5. Мал амьтан, гадны хүн орохооргүй, хашаа хамгаалалттай, битүүмжлэл сайтай, цоожтой, хаягжуулсан байна.

4.2.6. Эхэсийн нүхний хэмжээг тухайн эмнэлгийн төрөлтийн тоо, хөрсний нэвчүүлэх чадвараас хамаарч сонгох бөгөөд эхэсийн нүх нь 1 метрээс багагүй диаметртэй, 2 метрээс доошгүй гүн байна.

4.2.7. Нүхний хажуу ханыг шавар зэвэл цементийн зуурмагаар 10 см-ийн зузаан доторлож, тэгшлэх бөгөөд ёроолыг бүрэхгүйгээр хэвээр нь үлдээнэ.

4.2.8. Эмгэг хог хаягдлын хаталтыг түргэтгэх үүднээс нүхний ёроолд 40-80 мм-ийн диаметр бүхий чулуугаар 0,1 метрийн өндөртэй үе хийж, дараагаар нь 20-40 мм-ийн диаметр бүхий хайрга чулуугаар 0,4 метрийн өндөртэй үе хийнэ.

4.2.9. Нүхний амсар дээр шургааг, төмөр зэвэл төмөр бетон зэргийг дамнуулан тавьж, эргэн тойронд 100 см-ийн радиустай цементэн зуурмагаар бетондож, нүхний гол хэсэгт 20-40 см-ийн радиустай битүүмжлэл сайтай, гадагш нээгддэг бариул бүхий төмөр таг суурилуулах бөгөөд таглааг байнга хаалттай байлгаж цоожилно.

4.2.10. Орон нутгийн салбарын хяналтын газар, тухайн эрүүл мэндийн байгууллагын халдвартын сэргийлэлт, хяналтын алба/баг нь шинээр хийх эхэсийн нүхэнд явцын хяналт тавьж, ашиглалтад орсны дараа хүлээн авч баримтжуулна.


4.2.11. Эхэсийн нүхэнд эмгэг хог хаягдлаас бусад зүйлийг хийж болохгүй.

4.2.12. Хлор агуулсан химийн бодис нь хөрсний хүчиллэг /pH/ орчныг нэмэгдүүлснээр эмгэг хог хаягдлын задралыг удаашруулдаг тул эмгэг хог хаягдал болон эхэсийн нүхэнд халдвартгуйжүүлэлт хийхгүй. Эхэсийн нүхнээс гарах үнэрийг дарах зорилгоор нүүрс, үнс хийж болно.

4.2.13. Эмгэг хог хаягдлыг эхэсийн нүхэнд хаяхдаа гялгар уутгүйгээр нүхэнд шууд хийнэ.

4.2.14. Эхэсийн нүхний амсраас доош 0,5 метр хүртэл дүүрэхэд модны нүүрсээр бүрхэж, хөрсөөр дүүргэн битүүмжлэн булна. Нунтаг үнс хэрэглэж болохгүй.

4.2.15. Эхэсийн нүхэнд дэх эмгэг хог хаягдлын бүрэн задрал явагдах хугацаа нь тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалах бөгөөд эхэсийн нүхийг битүүмжилснээс хойш доод тал нь 2 жил дахин ашиглахгүй.



Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах аргууд

Ангилал	Халдвартай	Зүү хүрцүүлэх үзүүртэй иртэй	Эмтэг	Эмийн	Эсэд хортой	Химиин	Цараг идэвхит
Хяналттай 2 камертай шатаах зуух	✓	✓	✓	✓	✓	Бага хэмжээ	Бага хэмжээ
Химиин халдвартай халдвартай халдвартай	Бага хэмжээ	✓	✗	✗	✗	✗	✗
Автоклав	✓	✓	✗	✗	✗	✗	✗
Бичил долгион	✓	✓	✗	✗	✗	✗	✗
Капсулах	✗	✓	✗	✓	✗	✗	✗
Ландфилл	✗	✗	✗	Бага хэмжээ	Капсулах саны дараа	Капсулах саны дараа	✗
Бохирын шугамд хийх	Зөвхөн шээс, өтгөн	✗	✗	✗	✗	Бага хэмжээ	Бага хэмжээ
Бусад аргууд	-			Ханган нийлүү- лэгчид буцаах	Ханган нийлүү- лэгчид буцаах	Ханган нийлүү- лэгчид буцаах	Ханган нийлүү- лэгчид буцаах

Эх сурвалж: Healthcare or Medical Waste Basel Convention on the Control of Transboundary Movements of Hazardous Wastes and Their Disposal

---ооо---